

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

## ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 3 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Хорооны 2009 оны 36 дугаар тогтоолын талаар  
авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1 болон Компанийн тухай хуулийн 50.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигч хэвээр үлдэх хүсэлтээ ирүүлэн ногдол хувийн мөнгөө өөрийн дансанд буцаан байршуулсан энэ тогтоолын нэгдүгээр хавсралтад дурдсан нэр бүхий иргэдийн дансыг тусгаарлалтаас чөлөөлж, “Эрдэнэт хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчээр бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус үүрэг болгосугай.

2. Ногдол хувийн мөнгөө буцаан байршуулаагүй энэ тогтоолын хоёрдугаар хавсралтад дурдсан нэр бүхий иргэдийн 8 414 ширхэг хувьцааг “Эрдэнэт хивс” ХК-ийн халаасны хувьцаанд бүртгэхийг “ Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/ “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/ “Эрдэнэт хивс” ХК /ТУЗ-ийн дарга Ш.Энхбаяр, гүйцэтгэх захирал Ө.Мянганбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-г, олон нийтэд мэдээллэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ